

## Эфизол

Бүртгэлийн дугаар:01339

### НАЙРЛАГА

Шимж хэрэглэхэд зориулсан 1 шахмалд *эмийн бодис*: деквалины хлорид 0,25 мг, аскорбины хүчил 30 мг;

*туслах бодис*: глюкозын моногидрат, натрийн сахарин, пектин, ванилин, сукроза, какао, лактозын моногидрат, магнийн стеарат тус тус агуулагдана.

### ФАРМАКОЛОГИЙН ҮЙЛДЭЛ

Эфизол нь хэсэг газар үйлчилдэг үжилгүйжүүлэх үйлдэлтэй бэлдмэл бөгөөд янз бүрийн бичил биетэн, ялангуяа идээлүүлэгч нянгууд, тэр дундаа антибиотик эмчилгээ үр нөлөөгүй байгаа зарим штаммын үүсгэгчдийн үржил өсөлтийг зогсооно. Мөн мөөгөнцрийн (кандида, зарим эпидермофити, трихофити) эсрэг үйлдэл үзүүлнэ. Бэлдмэлийн нянгийн эсрэг үйлдэл нь бичил биетний уураг ба ферментэд нь нөлөөлөх болон нянгийн эсийн ханыг гэмтээж байгаатай тус тус холбоотой.

Аскорбины хүчил (витамин С) нь судасны ханыг нягтруулж нэвчимтгий чанарыг нь багасгах замаар цус алдалт болон хаван үүсэлтийг багасгах бөгөөд мөн үрэвслийн эсрэг үйлдэл үзүүлнэ.

### ХЭРЭГЛЭХ ЗААЛТ

Бэлдмэлд мэдрэг нянгаар үүсгэгдсэн амны хөндий ба залгиурын хөнгөн явцтай үрэвсэлт эмгэгүүдийн (буйлны улайлтат, шархлаат, фиброзон үрэвсэл, амны хөндийн үлхий үрэвсэл, кандидоз, залгиурын үрэвсэл, төвөнхийн үрэвсэл, гүйлсэн булчирхайн үрэвсэл, хэлний үрэвсэл) хэсэг газрын үжилгүйжүүлэх эмчилгээнд хэрэглэнэ. Мөн ам, залгиур орчмын мэс ажилбарын өмнө ба хойно халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэнэ.

Эфизолыг ам, залгиурын хүнд явцтай эмгэгүүдийн хавсарсан эмчилгээнд антибиотик болон сульфаниламидын бэлдмэлүүдтэй хавсруулан хэрэглэж болно.

### БЭЛДМЭЛИЙГ ХЭРЭГЛЭХЭЭС ӨМНӨ ЗАЙЛШГҮЙ МЭДЭХ МЭДЭЭЛЭЛ ЦЭЭРЛЭЛТ

Бэлдмэлийн бүрэлдэхүүн хэсгүүдэд хэт мэдрэг хүмүүст хэрэглэхийг цээрлэнэ.

### АНХААРУУЛГА

Бэлдмэлийн найрлаганд өвдөлт намдаах бодис байдаггүй учир түүнийг хүчтэй өвдөлт дагалдсан үрэвсэлт эмгэгийн үед хэрэглэхгүй. Халдварын тархалтын үндсэн шинж тэмдгүүд илэрсэн тохиолдолд бэлдмэлийг зайлшгүй системийн бактерийн эсрэг эмүүдтэй хамт хэрэглэнэ. Хэрэв Эфизолыг хэрэглэж байгаа үед ямар нэгэн гаж нөлөө илэрвэл эмчилгээг зогсоож өөр эмийн эмчилгээ хийнэ. Бэлдмэлийг хэсэг газар хэрэглэх бусад эмүүдтэй хамт хэрэглэх шаардлага гарвал эмчлэгч эмч шийдсэний дараа болон маш болгоомжтой хэрэглэнэ.

Бэлдмэл хэдийгээр бага хэмжээний сахар агуулах боловч чихрийн шижин өвчтэй хүмүүст маш болгоомжтой хэрэглэх бөгөөд цусан дахь сахарын хэмжээг хянан.

Хэрэв эмчилгээний үр нөлөө илрэлгүй өвчний шинж тэмдэг улам гүнзгийрвэл эмчээс зайлшгүй зөвлөгөө авна.

### ЭМИЙН БОЛОН БУСАД ХАРИЛЦАН ҮЙЛЧЛЭЛ

Эмийн бэлдмэлийн болон бусад хэлбэрийн харилцан үйлчлэлийн талаар мэдээлэгдээгүй байна. Харин кайексалаттай (цусан дахь калийн хэмжээ ихэссэн үед хэрэглэдэг бэлдмэл) хамт хэрэглэвэл арьс салст бүрхүүл, ялангуяа хоол боловсруулах замын салст бүрхүүлийн хүнд явцтай үхжилт гэмтэл үүсэх эрсдэл ихэсдэг байна.

### ОНЦГОЙ БҮЛЭГ ӨВЧТӨНҮҮДЭД ЗОРИУЛСАН АНХААРУУЛГА

Бэлдмэлийг 4-өөс доош насны хүүхдэд хэрэглэхгүй. Учир нь шахмал амьсгалын зам руу орох аюултай.

## **ЖИРЭМСЭН БА ХӨХҮҮЛ ҮЕИЙН ХЭРЭГЛЭЭ**

Бэлдмэл илэрхий гаж нөлөөгүй, хорон чанар багатай учир жирэмсэн ба хөхүүл үед хэрэглэж болно.

## **АВТОМАШИН БОЛОН ТЕХНИКТЭЙ АЖИЛЛАХ ЧАДВАРТ НӨЛӨӨЛӨХ НЬ**

Хөдөлгөөний урвал болон анхаарал төвлөрүүлэлтэнд ямар нэг сөрөг нөлөөгүй.

## **ЭМИЙН БЭЛДМЭЛИЙГ ЗӨВ ХЭРЭГЛЭХ МЭДЭЭЛЭЛ**

### **ХЭРЭГЛЭХ АРГА ТУН**

Шахмалыг зажлалгүй амандаа шимж хэрэглэнэ. Насанд хүрэгсэд болон 10-аас дээш насны хүүхдэд 1 ширхгээр 2-3 цагийн зайтай хэрэглэх бөгөөд хоногийн тун 8-10 шахмалаас илүүгүй байна.

4-10 насны хүүхдэд 1/2 шахмалаар 2-3 цагийн зайтай хэрэглэх ба хоногийн тун 4-5 шахмалаас илүүгүй байна. Бэлдмэлийг хэрэглэсний дараа хагас цаг юм идэж уухыг хориглоно. Эмчилгээ өвчний шинж тэмдэг арилснаас хойш 1-2 өдөр үргэлжилнэ.

Ээлж эмчилгээний ерөнхий үргэлжлэх хугацаа 5-7 хоногоос хэтрэхгүй байна. Учир нь амны хөндий ба залгиурын хэвийн бичил биетнүүд өөрчлөгдөх аюултай.

### **ТУН ХЭТЭРСНИЙ УЛМААС ИЛРЭХ НӨЛӨӨ**

Тогтоогдоогүй.

### **ГАЖ НӨЛӨӨ**

Бэлдмэл эдийг цочроохгүй, хүнд явцтай гаж нөлөөгүй бөгөөд ерөнхийдөө зохимж сайтай. Ховор тохиолдолд дотор муухайрах, бөөлжих, маш ховор тохиолдолд харшлын урвал, ам хатах, хорсох, цочрох зэрэг шинж ажиглагдаж болно. Эфизолыг удаан хугацаагаар хэрэглэвэл амны хөндийн хэвийн бичил биетнүүд өөрчлөгдөж болно.

### **ЭМИЙН ХЭЛБЭР, САВЛАЛТ**

Шимж хэрэглэхэд зориулсан шахмал хэлбэрээр үйлдвэрлэж 20 ширхгээр хөнгөн цагааны фольги-той блистертэй гаргана. 1 блистерыг картонон хайрцганд савлана.

### **ХАДГАЛАЛТ**

25°С-с доош хэмийн хүүхэд хүрэхээргүй, хуурай газар гэрлээс хамгаалж хадгална.

### **ЭМИЙГ ОЛГОХ НӨХЦӨЛ**

Жоргүй олгоно.

### **ХАДГАЛАХ ХУГАЦАА**

Үйлдвэрлэснээс хойш 3 жил. Хүчинтэй хугацаа дууссанаас хойш хэрэглэхгүй.

### **ҮЙЛДВЭРЛЭГЧ**

Балканфарма –Дупница АД, ул. Самоковское шоссе, 3, 2600 Дупница Болгария, тел.: (+359 701) 58 196, факс: (+359 701) 58 555